



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

- [f facebook.com/Rtcc.mn](https://www.facebook.com/Rtcc.mn)
- [g http://rtcc.mrtd.gov.mn](http://rtcc.mrtd.gov.mn)
- [✉ info@rtcc.mrtd.gov.mn](mailto:info@rtcc.mrtd.gov.mn)
- [☎ +976 77244409](tel:+97677244409)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН


2018 оны 11-р сарын дугаар



Төмөр замын салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг холбогдох журмын дагуу мэдээллээр хангах чиг уургийн хүрээнд Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн 2018 оны 10 дугаар сарын тээвэрлэлтийн мэдээг 2018.11.20-ны 298, 299 дугаартай албан бичгээр яамны ТЗДТБХЗГ, БТГ-т хүргэж танилцуулсан.



Мөн салбарын 2018 оны 10 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж, нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа болон зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч болон ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtd.gov.mn, төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.



Суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийж байна

Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, суурь бүтэц эзэмшигчийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хяналт тавих зорилгоор суурь бүтэц дэх зуны цагийн хуваарийн галт тэрэгний /2018 оны IV-IX сар/ хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд /төмөр замын тээврийн чанарын үзүүлэлт/ шинжилгээ хийж, шинжилгээний тайлан, зөвлөмжийг боловсруулж “Улаанбаатар төмөр зам” ХНН-т, ажлын үр дүнг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт танилцуулсан.

Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргийн хүрээнд суурь бүтцийн 2018 оны 10 дугаар сарын галт тэрэгний зурмагийн тасалдлын тайланг 2018.11.17-ны 295 дугаартай албан бичгээр яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргэж танилцууллаа.



Хөдлөх бүрэлдэхүүнд дугаар шинээр олгох үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна

Төвийн дүрэмд заасан “төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгох, бүртгэх” чиг үүргийн хүрээнд “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 2-р хэсэг. Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага MNS 6630-2:2016” стандартыг үндэслэн “МАК Цемент” ХХК-ийн эзэмшлийн 30 хөдлөх бүрэлдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэн дугаарыг баталгаажуулж, “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-ийн эзэмшлийн ачааны 14 хагас вагонд шинээр дугаар олгож, 2018.11.01-ний 281, 2018.11.21-ний 302, 2018.11.29-ний 316 дугаартай албан бичгээр хариу мэдэгдэв.



Хөдлөх бүрэлдэхүүний хяналтын шийдэл буюу “FRID” буюу радио соронзон долгион ашиглан хөдлөх бүрэлдэхүүнийг бүртгэх, хянах чип (СНIP), шошго (TAG) зэрэг шийдлүүдийг судалж танилцуулга бэлтгэж төмөр замын байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулан хяналтын системүүдийн шийдэлд санал авсан. Тус ажилтай холбоотойгоор “УБТЗ” ХНН-ийн Сүхбаатар өртөөнд сууринуулсан “АСКО ПВ” хяналтын камериийн системийн үйл ажиллагаа, программ хангамжтай танилцлаа. Уг томилолтын ажлын үр дүнд судалгаанд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн үнэ болон ажиллах горимын давуу болон сул талуудыг шинжлэн үнэлэлт дүгнэлтийг гаргалаа.

Мэдээ, мэдээлэл

Гадаад орны төмөр замын холбогдолтой Classic Trains, Railway Digest, The Railway Magazine, Modern Railways сэтгүүлийн 11 дүгээр сарын дугаарыг төвийн цахим хуудаст татаж авч үзэхээр байршууллаа.



Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажилд дэмжлэг үзүүлж ажиллав

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.09.11-ний өдрийн 197 дугаар тушаалаар батлагдсан Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж Сингапур Улсын төмөр замын тухай хууль, Солонгос Улсын нислэгийн хөдөлгөөн болон төмөр замын ослыг шинжлэн судлах тухай хууль, Финлянд Улсын төмөр замын тээврийн тухай хууль, Латви Улсын төмөр замын хууль, Гүрж Улсын төмөр замын тээврийн тухай хууль, БНСУ-ын логистикийн бодлогын тухай хууль, Төмөр замын барилгын ажлын тухай хуулийг /нийт 101 хуудас/ англи хэлнээс орчуулж яамны ТЗДТБХЗГ-т 2018.11.15-нд хүлээлгэн өгсөн.

ОХУ-ын төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм /103 хуудас/, ОХУ-ын Төмөр замын тээврийн хөрөнгийг захиран зарцуулах, удирдах онцлогийн тухай хууль /12 хуудас/, Казахстан Улсын Төмөр замын тээврийн тухай хууль /122 хуудас/-ийг орос хэлнээс орчуулж яамны ТЗДТБХЗГ-т 2018.11.17-ны 294 дугаартай албан бичгээр хүргэж танилцуулсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 13 дугаар тушаалаар батлагдсан төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй дүрэм, журмын Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлуулах хүрээнд “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ын төсөл дээр яамны холбогдох албан тушаалтнуудтай хамтран ажиллав.

Мэдээ, мэдээлэл



Олон Улсын стандартуудыг орчуулан боловсруулав

“Төмөр замын ачааны вагоны үйлдвэрлэлийн объект ТВ 10031-2009” 58 хуудас стандартыг хятад хэлнээс орчуулан боловсрууллаа.



Тус стандартын төсөлд ТЗДТБХЗГ, ХШУДАГ, “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК, ТДС-аас тус тус саналыг тусган Төмөр зам, далай ашиглалт ба усан замын тээврийн стандартчиллын Техникийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлээд байна.

ГОСТ 33435-2015 “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах, удирдах, хяналтын төхөөрөмжүүд, аюулгүй байдалд тавигдах шаардлага, хяналтын аргууд” стандарт (45 хуудас), О+Р 941 Мэдээллийн сан болон мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал санамж бичгийг (35 хуудас)-ийг орчуулан боловсрууллаа.



Зам, тээврийн хөгжлийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж байна

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж 2018.11.05-ны 285 дугаартай албан бичгээр яамны Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүллээ.

Зам, тээврийн салбарын болон төвийн өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ЗТХЯ-нд танилцуулж байна.



Япон Улсын Засгийн газрын тусlamжийн хөрөнгөөр баригдсан “Шилжүүлэн ачих цогцолбор” болон Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баригдаж буй Замын-Үүдийн логистикийн төвийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах болон төмөр замын хөгжил, салбарын ажилтнуудын нийгмийн асуудал сэдэвт зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Төмөр замын судалгааны нэгж” байгуулах асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.11.02-ны өдрийн 240 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төвийн захирал, холбогдох мэргэжилтнүүд ажиллаж байна.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсэг, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд заасан мэдээллийг rtcc.mrtd.gov.mn, info.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулж мэдээлж байна. Шилэн дансны хурээнд тухай бүр оруулах мэдээ, мэдээллийг хугацаанд нь тайлагнасан.



Төвийн мэргэжилтнүүд сургалтад тогтмол хамрагдаж байна

Хан-Уул дүүргийн “Албан бус - Насан туршийн боловсролын төв”-өөс зохион байгуулсан “Жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх нь” сэдвийн дор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Эмэгтэйчүүдийн эрх” болон “Жендерт суурилсан хүчирхийллээс өөрийгөө хамгаалах нь”“Авлига, авлигын гэмт хэрэг, авлигын хохирогч”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах нь”, “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үсийн гамшгаас хамгаалах” зэрэг сургалтуудад хамрагдсан.





 8-р давхар, Хан-Уул цамхаг,
Б.Шаравын гудамж 6,
З-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот 17042, Монгол Улс

